

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2026 оны 02 дугаар
сарын 16-ны өдөр

№ 05

Улаанбаатар хот

ХААН Банк ХК, Монгол Улсын нээлттэй хувьцаат компани (регистрийн дугаар 2693321, улсын бүртгэлийн дугаар 9007001013) (цаашид “Банк” гэх)-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд дараах тогтоолыг үүгээр батлав. Үүнд:

ҮНДЭСЛЭЛ: Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэгт Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол Төлөөлөн удирдах зөвлөл ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэрийг гаргах бөгөөд уг шийдвэрт хувьцаа бүрд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр болон ногдол ашиг төлөх өдөр зэргийг заах болохыг;

ҮНДЭСЛЭЛ: Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5 дахь хэсэгт Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх талаар хэлэлцэн шийдвэрлэсэн байхаар заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Банкны Дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.13.14 дэх заалтад Банкны Төлөөлөн удирдах зөвлөл нь Банкны Дүрэмд өөрөөр заагаагүй бол ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэр гаргах, ногдол ашгийн хэмжээ, түүнийг төлөх журмыг тодорхойлохоор заасныг;

ҮНДЭСЛЭЛ: Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 26 тоот тогтоолын Хавсралт №1-ийн дагуу баталсан “ХААН Банк ХК-ийн Ногдол ашгийн бодлого”-ыг

ТУС ТУС ҮНДЭСЛЭН, ийнхүү:

- 1. ТОГТООХ НЬ:** Банкны 2025 оны санхүүгийн гүйцэтгэлд тулгуурлан татварын дараах цэвэр ашиг болох 694,847,217,071.08 (*Зургаан зуун ерэн дөрвөн тэрбум найман зуун дөчин долоон сая хоёр зуун арван долоон мянга далан нэгэн төгрөг найман мөнгө*) төгрөгийн 58.8921 хувь буюу 409,210,372,000 (*Дөрвөн зуун есөн тэрбум хоёр зуун арван сая гурван зуун далан хоёр мянган*) төгрөгийг нэгж хувьцаанд 214.00 (*Хоёр зуун арван дөрвөн төгрөг*) төгрөгөөр тооцож, ногдол ашгийг мөнгөн хэлбэрээр хуваарилахыг зөвшөөрсүгэй.
- 2. ТОГТООХ НЬ:** Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тасалбар болгон тогтоосугай.
- 3. ТОГТООХ НЬ:** Ногдол ашиг хуваарилахтай холбоотой эрх бүхий зохицуулагч байгууллагын зохих зөвшөөрлийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-иар дамжуулан ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулан тараасугай.